

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ УРИЛГА

Он, сар, өдөр: 2022.06.17

Сонгон шалгаруулалтын нэр: Сантехникийн сэлбэг хэрэгсэл

Сонгон шалгаруулалтын дугаар: EGD-2022/17

1. “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК нь “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Сантехникийн сэлбэг хэрэгслийг нийлүүлэх зорилгоор битүүмжилсэн иж бүрэн санал ирүүлэхийг урьж байна.
2. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн эрх бүхий оролцогч нь энэхүү урилгад заасан холбоосоор Захиалагчаас ажлын өдрүүдэд 09:00-12:00 цагийн хооронд нэмэлт мэдээлэл авч болно.
3. Сонирхсон оролцогч нь Захиалагчид бичгээр эсхүл цахим шуудангаар хүсэлт гаргаж, 55,000 (тавин таван мянга) төгрөг /НӨАТ орсон үнэ/-тэй тэнцэх хураамжийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр төлснөөр Монгол хэл дээр бэлтгэгдсэн Сонгон шалгаруулалтын баримт бичгийг цаасаар эсхүл .pdf өргөтгөлтэй файл хэлбэрээр худалдан авч болно. Төлбөрийг Захиалагчийн **Голомт банкин дах 8125100892** тоот дансанд шилжүүлж, төлбөрийн баримтыг хүсэлтийн хамт хүргүүлнэ.

**Цахим шуудангаар илгээсэн хүсэлт ирээгүй, хугацаа хоцорч ирсэн, төлбөрийн баримт хаягдсан, баримт бичиг, тодруулга хугацаа хоцорч хүргэгдсэнтэй холбоотойгоор Захиалагч ямар нэг хариуцлага хүлээхгүй.*

4. Сонгон шалгаруулалтанд ирүүлэх саналаа 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 12:30 цагт эсхүл түүнээс өмнө урилгад заасан хаягаар ирүүлнэ. Хугацаа хоцорсон саналыг хүлээн авахаас татгалзана. Сонгон шалгаруулалтад ирүүлсэн саналуудыг “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Захиргааны барилгын 2 давхар 201 тоотод 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 13:00 цагт бүртгэж, нийтэд мэдээлэх ба сонгон шалгаруулалтад оролцогчид, тэдгээрийн төлөөлөл, сонирхсон бусад этгээд оролцох эрхтэй.
5. Санал бэлтгэх эсхүл хүргэхтэй холбоотойгоор сонгон шалгаруулалтад оролцогчийн зүгээс гаргасан аливаа зардлыг Захиалагч хариуцахгүй.
6. Ирүүлсэн саналуудыг нээх, үнэлэх, гэрээ байгуулах эрх олгохдоо Сонгон шалгаруулалтын баримт бичигт заасныг дагаж мөрдөнө.

Хаяг: Монгол улс, Төв аймаг, Сэргэлэн сум, 4-р баг, Эрдэнэ-Уул 41090, Тахилт толгой

Холбоо барих утас, цахим шуудан: 7128-7421, procurement@nubia-llc.mn

“Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК